

- 4.2.3. Гадаад, дотоодын байгууллага, иргэдтэй шинжилгээсудалгааны чиглэлээр харилцан туршлага солилцох, хамтран ажиллах;
- 4.2.4. Тамирчин, дасгалжуулагч бэлдэх олон улсын туршлага, арга техникийг судлан боловсруулах;
- 4.2.5. Тамирчин, дасгалжуулагч, шүүгч, мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэхэд байнга анхаарч Олон Улсын Уулын Спортын Холбоо (UIAA), Азийн Уулын Спортын Холбоо (UAAA)-с зохион байгуулах үйл ажиллагааны мэдээ, мэдээллээр тухай бүрт нь хангах, төрөл бүрийн уулзалт, лекц, семинар зохион байгуулж, тэдгээрийг хамруулах;
- 4.2.6. Уулын спортыг сонирхогч, хүүхэд залуучуудболон бусад сонирхогчдыгуулын спортынталаарх мэдээ, мэдээлэл, гарын авлага, бусад материалаар хангах;
- 4.2.7. Өсөх ирээдүйтэй, авъяаслаг тамирчдыг сонгон шалгаруулж, үндэсний шигшээ багийн залгамж халааг бэлтгэх;
- 4.2.8. Уулын спорт өндөр хөгжсөн орнуудаас мэргэжилтэн урьж ирүүлэх, харилцан туршлага солилцох, хамтарсан бэлтгэл, цугларалт, сургуулилалт хийх ажлыг зохион байгуулах;
- 4.2.9. Тамирчин, дасгалжуулагч, шүүгч, мэргэжилтнүүдийн мэдлэг чадварын түвшинг тогтоох, дээшлүүлэх ажлыг зохион байгуулах.
- 4.3. Уулын спортын уралдаан, тэмцээн зохион байгуулах ажлын хүрээнд:
 - 4.3.1. Монгол улсад олон улс, тив, бүс нутгийн хэмжээний тэмцээн;
 - 4.3.2. Монголын Уулчдын Үндэсний Холбооны нэрэмжит аварга шалгаруулах тэмцээн;
 - 4.3.3. Монгол Улсын аварга шалгаруулах насанд хүрэгчид, залуучууд, өсвөр үеийн тэмцээн;
 - 4.3.4. Нийслэл, орон нутгийн болон бусад нэрэмжит тэмцээн, уралдаан.
- 4.4. Төр, олон улсын байгууллага болон бусад байгууллага, иргэдтэй хамтран ажиллах хүрээнд:
 - 4.4.1. Төрөөс уулын спортыг хөгжүүлэхэд баримтлах бодлогыг тодорхойлуулах санаачлага гарган мэргэжлийн байгууллагын хувьд идэвхтэй хамтран ажиллах;
 - 4.4.2. Бизнесийн байгууллагыг уулын спортыг хөгжүүлэх үйл ажиллагаанд харилцан ашигтай зарчмаар, боломжит бүх арга, хэлбэрээр татан оролцуулж, хамтран ажиллах;
 - 4.4.3. Батлан хамгаалахын салбарын байгууллагууд болох, тухайлбал Онцгой байдлын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Батлан хамгаалах сургууль зэрэг байгууллагуудтай уулын спорт, түүн дотор уулын аврах ажиллагааны чиглэлд мэргэжлийн зөвлөгөө өгч, харилцан хамтран ажиллах;
 - 4.4.4. Биеийн тамир, спортын газар, Монголын Үндэсний Олимпийн Хороо, Олон Улсын Уулын Спортын Холбоо (UIAA), Азийн Уулын Спортын Холбоо (UAAA), Олон Улсын Спорт Авиралтын Холбоо (IFSC) болон бусад гадаад улсын уулын холбоодтой хамтран ажиллах, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцож, хамтын ажиллагаа явуулах;
 - 4.4.5. Дэлхийн допингийн эсрэг байгууллага (WADA), Үндэсний допингийн эсрэг байгууллага (NADA) нарын допингийн эсрэг гаргасан бүхий л дүрэм, журам, зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж хамтран ажиллана.